

ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 5 дугаар сарын 13

№ 14

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 08 цаг 00 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд хуралдав. Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинбат удирдаж, хуралд нийт 15 удирдах албан тушаалтнууд оролцохоос 15 оролцож хуралдааны ирц 83.3 хувьтай байв. Гишүүдийн ирцийн бүртгэлийг хавсаргав.

ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1.Хэлтэс, алба, сумдын дарга нарын өнгөрсөн 7 хоногийн ажлын тайлан, холбогдох шуурхай мэдээ, мэдээллийг танилцуулах, өмнөх шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг танилцуулах.

Хуралд оролцсон хэлтэс, албад, сумдын дарга нар өнгөрсөн 7 хоногт хийсэн ажлын тайланг танилцуулав.

ҮҮРЭГ ДААЛГАВАР:

Спорт цогцолборын зураг төсөлтэй холбоотой өөрчлөлтүүд барилгын ажилд саад болж байгаа тухай албан бичиг надад ирсэн. Албан бичгийн хариуг яаралтай өгөх хэрэгтэй. Нэмэхбаяраа олъё. Уузалт хийе. Барилгын угсралтын ажлыг төлөвлөгөөний дагуу хугацаанд нь явуулах хэрэгтэй байна. Уг ажилд Нийгмийн бодлогын хэлтсийн дарга хяналт тавьж ажиллах хэрэгтэй. Албан бичгийн хариуг нь яаралтай өгье.

Авилгатай тэмцэх газраас Дархан-Уул аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын эрхлэгч, нягтлан бодогч нартай холбоотой асуудлыг шалгаж буй талаарх мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр өгсөн. Мөн өнгөрсөн 7 хоногт Авилгатай тэмцэх газраас аймгийн Засаг даргад зөвлөмж, шаардлага ирсэн. Асуудалд холбогдсон 5 хүн байна. Жигүүр цогцолбор сургуулийн захирал Давааням хамаатныхаа хүнийг жижүүрээр авсан. Өөрөө ч аваагүй юм байна. Энэ нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр явсан. Бид иргэдэд үнэн бодитой мэдээллийг өгч байх ёстой. Уг асуудалд Мэдээлэл, технологийн алба анхаарч ажиллах хэрэгтэй байна. Цаашид сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нартай холбоотой асуудал дахин гаргахгүй байхад анхаарч ажиллах ёстой. АТГ-аас ирүүлсэн бичиг дээр авсан арга хэмжээг олон нийтэд ил тод мэдээллэх гэсэн байсан. Үүнийг МТА мэдээллэе. Энэ 7 хоногт бүх сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нартай уулзалт хийе. Зөрчлүүд ч байсан. Худалдан авах ажиллагааны тухай хуулиар хувааж зарлах ёстой байсан тендерүүдийг анхаарах

Багш нарын үр дүнгийн урамшуулал бусад аймгаас бага орж ирсэн. Үүнээс үүдэж багш нар жагсах гэж байна гэж СТСХ-ээс мэдээлэл хийлээ. Н.Цасчихэр дарга үүнийг нягтлах шаардлагатай байна. 2017 онд Чулуунбаатар сайдыг байхад албан бичиг буруу төлөвлөсөн мэргэжилтнээс болж урамшууллын мөнгө дутуу ирж байсан тохиолдол гарсан. Үүнийг би шалтгааныг илрүүлж залруулж байсан. Ийм төрлийн алдаа гарсан байх вий. НБХ-ийн дарга та нягтлаарай. Яагаад манай аймгийн багш нарын урамшуулал бусад аймгаас бага байгааг тодруулаарай.

2018-2019 оны хичээлийн жилд бусад жилүүдээс цөөн тооны сурагч ерөнхий боловсролын сургуулийг төгсч байна. Дархан-Уул аймагт 428 сурагч элсэлтийн ерөнхий шалгалт өгөх боломжтой байна. Үүнээс 234 сурагч 5 судлагдахуунаар урьдчилсан шалгалт өгсөн. Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудыг их, дээд сургуулийн консорциумтай холбож өгөх хэрэгтэй байна. Мэргэжил таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулъя. Орон нутгийн их, дээд сургуулиудыг дэмжиж ажиллах хэрэгтэй байна.

Хурал 9 цаг 20 минутад дуусав

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС